

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын нисэхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

**1/5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт:**

5.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийг томилох, дүрмийг батлах;

**2/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

“11.3.Энэ хуулийн 10.1.1 дэх заалтаас бусад нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал хэрэгжүүлнэ.

**3/14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг:**

14.6.Улсын нисэхийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс улсын агаарын хөлгийг ашиглах гарын авлага, техник технологийн болон бусад холбогдох баримт бичгийг тухайн үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглаж болно.

**2 дугаар зүйл.** Улсын нисэхийн тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/7 дугаар зүйл:**

**“7 дугаар зүйл.Улсын нисэхийн багц дүрэм**

7.1. Улсын нисэхийн багц дүрмээр дараах харилцааг зохицуулна:

7.1.1.улсын агаарын хөлгийг бүртгэх, гэрчилгээ олгох;

7.1.2.улсын агаарын хөлгийн нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүнд мэргэжлийн үнэмлэх олгох;

7.1.3.улсын нисэхийн аэродромын бүсэд нислэг үйлдэх болон аэродромыг ашиглах;

7.1.4.улсын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт тавих;

7.1.5.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагааг

зохицуулах;

7.1.6.эрэн хайх, авран туслах ажиллагааг гүйцэтгэх;

7.1.7.улсын нисэхийн агаарын хөлгийн нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах;

7.1.8.хууль тогтоомжид заасан бусад харилцаа.

## **2/10 дугаар зүйл:**

### **"10 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал**

10.1.Улсын агаарын хөлгийн нислэг дараахь ангилалтай байна:

10.1.1.байлдааны үүргийн нислэг;

10.1.2.онцгой үүргийн нислэг;

10.1.3.тусгай үүргийн нислэг;

10.1.4.төлбөрт нислэг;

10.1.5.сургууль-байлдааны нислэг;

10.1.6.шалгалт, туршилтын нислэг.

10.2.Байлдааны үүргийн нислэгт байлдааны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон бүх төрлийн нислэгүүд хамаарна.

10.3.Онцгой үүргийн нислэгт Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын өндөр хэмжээний зочдод үйлчлэх нислэгүүд хамаарна.

10.4.Тусгай үүргийн нислэгт тайван цагийн батлан хамгаалах нислэг, хил хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэхтэй холбогдолтой нислэг, байгалийн гамшиг, хүн, мал, амьтны гоц халдварт болон ургамлын өвчинтэй тэмцэх, эмнэлгийн яаралтай түргэн тусламж, спортын арга хэмжээ болон төрийн чиг үүргийг гүйцэтгэх байгууллагуудын ажил, үүргийг гүйцэтгэх зорилгоор үйлдэх нислэгүүд хамаарах ба нислэг, түүнтэй холбогдон гарах зардлыг захиалагч байгууллага хариуцна.

10.5. Улсын агаарын хөлгөөр төлбөрт нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хуулийг баримтална.

10.6.Сургууль-байлдааны нислэгт бүх төрлийн дадлага сургалт, эрх олгох, бөмбөгдөлт, пуужингийн харвалт, буудлагатай нислэг хамаарна.

10.7.Шалгалт, туршилтын нислэгт шинэ төрлийн агаарын хөлгийг агаарт шалгах, засвар, үйлчилгээний дараах шалгалтын нислэгүүд хамаарна."

## **3/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:**

"11.1.Улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын шийдвэрээр Агаарын цэргийн командлал хэрэгжүүлнэ."

#### **4/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:**

“18.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч нь улсын нисэхийн нислэг техникийн шинжлэн шалгах комисс томилуулах тухай саналаа Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, батлуулна.”

**3 дугаар зүйл.** Улсын нисэхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Улсын” гэснийг “Байлдааны агаарын хөлгөөс бусад улсын” гэж, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “Улсын” гэснийг “Сургууль-байлдааны нислэгээс бусад тохиолдолд улсын” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2018 оны ... дугаар ... сарын ... –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ